



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 01 дугаар
сарын 19-ны өдөр

Дугаар ХЭГ/
163

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.НЯМБААТАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Ашигт малтмал хайх, ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, энэ талаар гарч байгаа зөрчил, хариуцлага хүлээлгэсэн байдал, төрд учруулсан хохирлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАРААС ЕРӨНХИЙ САЙД
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

*Нэг.2016-2017 онд иргэн, аж ахуй нэгжээс байгаль орчинд хийсэн
нөхөн сэргээлтийн талаар*

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д заасан байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах чиг үүргийн хүрээнд 30 орчим дүрэм, журам баталж, уул уурхайн ашиглалтын үед мөрдүүлж байна.

2015-2017 онд байгаль орчны асуудал эрхэлсэн сайд болон холбогдох салбарын сайд нарын хамтарсан тушаалаар “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”, “Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах актын загвар”, “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд орсон байгаль орчныг нөхөн сэргээх үр дүнг хүлээн авах журам”, “Байгаль орчны хохирол тооцох амьдрах орчны үнэлгээний аргачлал”, “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал”, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загвар, мэдээний маяг”-ыг баталсан.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3-д заасан тайлан, мэдээг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрий дотор ирүүлдэг бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас 2006-2016 онуудад эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээллийг 1 дүгээр хавсралтаар хүргүүлж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-04 тоот тушаалаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” батлагдан мөрдөгдөж байна. Энэхүү журмаар бүх төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг тусгай дансанд байршуулах үйл ажиллагаа зохицуулж байна. 2017 оны эцсийн байдлаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 12.4 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт:1.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд орсон барьцаа хөрөнгө /2007-2017 он/



Хоёр.Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхой дурдсан. Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1, 24.2.2-т заасан гэмт хэрэг үйлдсэн иргэн, хуулийн этгээдийн гэмт үйлдлийг мөрдөн шалгаж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан талаар:

Улсын хэмжээнд 2017 онд 32259 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 330 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 1.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэ төрлийн гэмт хэрэг 2 дахин өсч, илрүүлэлт 52.3 хувьтай байна.

д/д	Он	Бүртгэгдсэн хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	Хэргийн өсөлт /хувиар/
1.	2016 он	165	
2.	2017 он	330	2 дахин

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн 107 буюу 32.4 хувь нь Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэг байна.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72 нэгжээр буюу 2.1 дахин, хэргийн илрүүлэлт 67.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

д/д	Он	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг	Хэргийн өсөлт /хувиар/
1.	2016 он	35	
2.	2017 он	107	2.1 дахин

Бүртгэгдсэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн 107 хэргээс 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 6 хэргийг бусад хэрэгт нэгтгэн, 34 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын хяналтад хүргүүлж, одоо 66 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна.

Шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлсэн 34 хэрэгт 738.6 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 74.5 хувь буюу 243.1 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 307.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Гурав.Ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, байгаль орчин нөхөн сэргээхтэй холбоотой төрийн байгууллагаас гаргасан хичнээн хууль бус шийдвэр, тусгай зөвшөөрлийг цуцалсан, хууль бус шийдвэр гаргаж төрд хохиролч учруулсан хэдэн албан тушаалтанд хариуцлага тооцож, хэдэн га газарт төрийн зардлаар нөхөн сэргээлт хийсэн, хэдэн төгрөгийн хохирол учирсныг буруутай этгээдээр төлүүлсэн талаар:

2017 оны байдлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уул уурхайн ашиглалтын 385 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө бүртгэгдсэнээс 318 төлөвлөгөө батлагдсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал болон Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргийн хэрэгжилтэд 2017 онд нийт 4 удаагийн шалгалт хийсэн.

Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Сэлэнгэ, Дархан-Уул, Архангай, Төв, Булган, Ховд аймгуудын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг мөрдөх хэлтсийн холбогдох ажилтнууд, тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтад 10 аймгийн 20 гаруй суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 аж ахуйн нэгж, 20 бичил уурхай эрхлэгч, 80 гаруй хууль бусаар ашигт малтмал ашиглагчид хамрагдсан байна.

Шалгалтын дүнг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулан 36 тоот тэмдэглэл гарсан. Тэмдэглэлээр Архангай, Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул зэрэг аймгуудын Засаг дарга нарт хууль бусаар ашигт малтмал ашиглагчдыг албадан буулгах үүрэг өгөгдсөн бөгөөд Архангай, Төв, Булган, Дархан-Уул зэрэг аймгуудаас мэдээ ирээд байна.

Энэ ажлын хүрээнд нийт 22 аж ахуйн нэгж, 28 нөхөрлөл, 23 иргэний алт олборлож байсан үйл ажиллагааг зогсоож, 15 аж ахуйн нэгж, 8 иргэний асуудлыг Цагдаагийн байгууллагад шалгуулахаар хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай асуудлыг боловсруулан танилцуулсан.

Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын нутагт ашиглалт хийж буй “Юу Энд Би” ХХК нь MV-002810 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2016, 2017 онд уурхайн олборлолтын ажил эхлүүлэхэд шаардагдах баримт бичиггүй хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тул Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.5 дахь заалтын дагуу 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 17/01 тоот дүгнэлт гарган Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Ховд аймгийн Булган суманд хууль бусаар алт ашиглаж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар мэдээллийг газар дээр нь шалгах, илэрсэн зөрчлийг арилгах, баримт материал бүрдүүлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилготой ажиллаа. Шалгалтын ажлын үр дүнд зөрчилтэй үйл ажиллагаа явуулж байсан “Пүрэв даш” ХХК-тай Булган сумын Засаг дарга байгуулсан Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх тухай 01 тоот ажлын гэрээг Булган сумын Засаг даргын 2017 оны 7 дугаар сарын 19-ний А/89 тоот захирамжаар цуцлуулсан.

2015-2017 оны байдлаар 15 аймгийн нутаг дэвсгэрт газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын 30 гаруй хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулсан. Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2015 онд 339.2 га, 2016 онд 300.8 га, 2017 онд 335.5 га-д хийсэн бол биологийн нөхөн сэргээлтийг 2015 онд 63.6 га, 2016 онд 19.4 га, 2017 онд 77.5 га талбайд хийсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасны дагуу 2016-2017 онуудад цуцлагдсан тусгай зөвшөөрлийн мэдээллийг 2 дугаар хавсралтаар хүргүүлж байна.

---oOo---

ЭВДРЭЛД ОРСОН БОЛОН НӨХӨН СЭРГЭЭСЭН ТАЛБАЙН МЭДЭЭ

2016 онд уул уурхайн олборлолтын улмаас шинээр эвдрэлд орсон газрын хэмжээ 843 га, техникийн нөхөн сэргээлт 811,5 га-д, биологийн нөхөн сэргээлт 574,7 га-д тус тус хийгдсэн байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 27654 га талбай уулын ажилд хамрагдсан. Үүнээс техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 12057 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 7949 га, нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал 94,775.0 сая төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 60,622.0 сая төгрөг байна.

Уул уурхайн салбарын нөхөн сэргээлт, 1997-2006-2016

Үзүүлэлт		Өмнөх онуудад	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016*	НИЙТ
1	Уулын ажилд хамрагдсан талбай /га/	14640	1001	1436	709	631	1709	2042	1430	1038	1561	613	843.40	27654
2	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай /га/	9046	1125	1356	932	711	1533	1443	1402	807	960	571	574.6	20461
3	Нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал /сая.төг/	11183	4662	8960	7683	8300	9657	7013	14808	7382	9212	3231	2684.8	94775
4	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	3558	843	980	823	580	1290	480	1177	532	523	460	811.5	12057
5	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	2395	628	1001	670	300	520	521	378	370	322	271	574.7	7949
6	БОХ зардал / сая.төг/	6030	2488	3501	3592	4158	5708	3323	8597	3876	11683	3771	3895.0	60622
7	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт, га												11240.4	11240.4
8	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт, сая төг.												430.2	430.2
9	Уурхайг тохижуулах, тосгон орчим хийгдсэн нөхөн сэргээлт, га												27.9	27.9
10	Уурхайг тохижуулах, тосгон орчим хийгдсэн нөхөн сэргээлт, сая төг.												163.9	163.9

Эх үүсвэр: Аж ахуйн нэгжүүдээс АМГТГ-ын УУҮТ хэлтэст ирүүлсэн 210 уулын ажлын тайлан
тайлбар: 2016 оны үзүүлэлтүүд хүлээгдэж буй гүйцэтгэлээр /2017.12.12-оор/

Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүйн улмаас цуцлагдсан АТЗ-үүдийн жагсаалт

Д/д	Жагсаалт	ТЗ-ийн дугаар	Аймаг/Хот	Сум/Дүүрэг	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	ААН-ийн төрөл	Эзэмшигчийн регистр #	Шийдвэрийн огноо	Шийдвэр #	Олгосон огноо	Дуусах огноо
1	МВ-002810-018-RN	2810	Хэнтий	Батширээт Биндэр	Гутайн даваа	341.79	Ю энд Би	ХХК	2572036	2017.07.25	429	#####	2017.07.25
2	МВ-010423-016-RN	10423	Улаанбаатар	Налайх	Их уурхай	15.94	Жиншентан	гадаадын 100% ХО-тай ХХК	5134803	2017.10.23	626	#####	2017.10.23
3	МВ-002645-020-RN	2645	Улаанбаатар	Налайх	53-р уклоны зүүн жигүүр	5.46	Ордтрейд	ХХК	2026236	2017.10.23	626	#####	2017.10.23